

## “ЭХ БАРИХ, СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ТАЙЛАН

2024.05.06

Улаанбаатар хот

Олон улсын сувилагчийн өдрийг угтан зохион байгуулж буй “Эх барих, сувилахуйн тусламж үйлчилгээний тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээ судалгааны хурлыг 2024 оны 05-р сарын 03-ний өдөр зохион байгуулан ажиллалаа. тус хуралд сувилагч, эх баригч нарын илгээсэн 15 судалгааны ажлыг хүлээн авч хэлэлцүүлэгдэв.

Эрдэм шинжилгээний бага хурлын шүүгчээр:

- У.Цэвэгмид Анагаах ухааны доктор, дэд захирал, Эрдэмтэн нарийн бичгийн дарга
- Э.Саруулсайхан Анагаах ухааны доктор, Эрдмийн зөвлөлийн гишүүн
- С.Оюунгэрэл Сувилахуйн ухааны магистр, Зөвлөх зэрэгтэй, МЗСНийгэмлэгийн тэргүүн, ГУИС-ийн төрөлжсөн сувилахуйн тэнхимийн эрхлэгч
- З.Уранчимэг Эрүүл мэндийн бодлого, удирдлагын магистр, Тэргүүлэх зэрэгтэй. Нийгмийн сэтгэл судлаач, ГУИС-ийн насанд хүрэгчдийн тэнхимийн эрхлэгч
- Г.Батхуяг Уламжлалт анагаах судлалын магистр, доктрант, Суурь сувилахуйн тэнхимийн эрхлэгч нар судалгаа илтгэлүүдийг шүүж, илтгэл хэлэлцүүлсэн сувилагч, эх баригч судлаач нарт судалгааны арга зүйн талаар үнэтэй, зөвлөгөөг өгөв.



Эрдэм шинжилгээ, судалгааны хуралд оролцсон эх баригч, сувилагч судлаач нарыг байр эзлүүлэн мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Үүнд:

1 Тэргүүн байранд:

Жирэмсний эмгэгийг эмчлэх эх баригч Б.Амгалан "Жирэмсэн үеийн стресс түгшилтийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан нь" сэдэвт илтгэл

2 Дэд байранд:

Төрсний дараах тасгийн эх баригч П.Бүжинлхам "Дунд насны эмэгтэйчүүдийн амьдралын чанарт цэвэршилтийн нөлөөлөх байдал" сэдэвт илтгэл

3 Гутгаар байранд:

Амбулаторийн тасгийн ахлах эх баригч С.Оюун "Нярайн эгэмний гэмтэл" сэдэвт илтгэлүүд тус тус шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар урамшуулав.



**Дүгнэлт:** “Эх барих, сувилахуйн тусламж үйлчилгээний тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний хурал амжилттай зохион байгуулагдаж нийт 15 судалгааны ажлууд хүлээн авч хэлэлцүүлэгдсэн.

Шүүгч нар илтгэгч нарт үнэтэй зөвлөгөө өгч, дараа дараагийн судалгааны ажлуудаа үр дүнтэй хийх талаар санал хэлж цаашдын судалгааны ажилд амжилт хүссэн.

Шүүгч С.Оюунгэрэл судалгааныхаа зорилго, зорилт, ач холбогдолоо сайн уяалдуулж бич, сайн уншиж судал, алдаагаа сайн хяна, бодитоор дүгнэлтээ бич. Судалгаагаа яаруу сандруу бичсэн байна. Судалгааг сонгож авахдаа ямар ач

холбогдолтой юм ач холбогдолоо судалж байж бичих хэрэгтэй. Сэдвээ том агуулгаар сонгож аваад байна, жижиг агуулгаас томруулж бичиж болдог зэрэг зөвлөгөөг өгөн ажилласан.

Оролцсон нийт судлаач нарт талархал илэрхийлж, ажлын өндөр амжилт хүсэн ерөөсөн.